

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИЖ БУЙ ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙГЭЭС ШАЛТГААЛЖ ТӨЛӨВЛӨСӨН ХУГАЦААНД АШИГЛАЛТАД ОРООГҮЙ БАЙНА.

УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ӨВА-2026/05-14-ШТА-НА



Энэхүү аудитын тайлангийн цахим хувилбарыг дээрх QR кодоор, тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг доорх хаягаар авна уу.
www.audit.mn, www.open.audit.mn

Өвөрхангай аймаг дахь Төрийн Аудитын газрын Дарга,
Тэргүүлэх аудитор О.Батжаргал
Утас: 70323253
Цахим шуудан: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер П.Хорлоосүрэн
Утас: 70323108
Цахим шуудан: KhorloosurenP@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Баяртогтох
Утас: 70323108
Цахим шуудан: Bayartogtokhb@audit.gov.mn

Аудитор Г.Нинжбадгар
Утас: 70323833
Цахим шуудан: Ninjbargarg@audit.gov.mn

Аудитор Р.Цэрэндолгор
Утас: 70323833
Цахим шуудан: TserendolgorR@audit.gov.mn

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт.....4

Зургийн жагсаалт.....4

Дүрслэлийн жагсаалт.....4

БҮЛЭГ 1. ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ 2025 ОНД ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ БАЙХГҮЙ БАЙНА.8

БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД 2025 ОНД ШИНЭЭР ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛЭЭГҮЙ ТУЛ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.8

БҮЛЭГ 3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛСНААС ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ТӨЛӨВЛӨСӨН ХУГАЦААНД АШИГЛАЛТАД ОРООГҮЙ БАЙНА.9

 A.1. Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг зохиогчийн зөвшөөрөлгүй зураг төсөлд өөрчлөлт оруулж гүйцэтгэсэн байна.9

 A.1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нь нэмэгдсэнээс шалтгаалж гэрээний хугацаанд дуусаагүй байна.9

 A.1.2. Тайлант онд төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн олгосон санхүүжилт 85.7 хувьтай байна. 11

 A.1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим төсөл, арга хэмжээг зохиогчийн зөвшөөрөлгүй зураг төсөлд өөрчлөлт оруулж гүйцэтгэсэн байна. 13

 A.1.4. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээ дүгнэх маягтаар баталгаажуулж ажилласан байна. 16

 A.2. Комиссын гишүүдийн үүрэг даалгаврыг бүрэн биелүүлээгүй, гэрээнд заасан ажлыг гүйцэтгээгүй байхад комиссын дүгнэлт гарган барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авсан байна. 16

 A.2.1. Авто замын ажлын хувьд захиалагч болон зохиогчийн хяналтын гэрээ байгуулаагүй нь авто зам, замын байгууламжийн ажил чанаргүй хийгдэх эрсдэлтэй байна. 16

 A.2.2. Барилгын материал, хийц, бүтээцийн эрүүл ахуйн шаардлагыг лабораторийн шинжилгээ, дүгнэлтээр баталгаажуулж, хяналт хэрэгжүүлэх шаардлагатай байна. ... 18

 A.2.3. Комиссын гишүүдийн үүрэг даалгаврыг бүрэн биелүүлээгүй, гэрээнд заасан ажлыг гүйцэтгээгүй байхад комиссын дүгнэлт гарган барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авсан байна. 19

 A.2.4. Төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулсан эсэхэд захиалагч хяналт хэрэгжүүлээгүй байна.22

 A.3. Дуусаагүй барилга байгууламжид ашиглагч байгууллага үйл ажиллагаа явуулж байна. 23

 A.3.1. Тайлант онд ашиглалтад хүлээн авсан 11 барилга байгууламжийг бүртгэж, зориулалтын дагуу ашиглаж байна. 23

 A.3.2. Зарим салбарын хувьд төсөл, арга хэмжээний хэрэгжилт, зорилтот түвшин, хүрэх үр дүнг чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэхүйц, тодорхой байдлаар тусгах шаардлагатай байна. 26

 A.3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээнүүд хэрэгжсэнээр төлөвлөсөн бодлогын зорилтот үр дүнд хүрсэн байна. 28

 A.3.4. Сүүлийн жилүүдэд нийт илэрсэн зөрчлийн тоо өссөн боловч, төлбөрийн акт, хариуцлага тооцуулах албан шаардлага буурсан үзүүлэлттэй байна. 28

АУДИТЫН ДҮГНЭЛТ:..... 40

ЗӨВЛӨМЖ: 41

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ББКД	Барилга байгууламжийн комиссын дүгнэлт
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТӨӨЗ	Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт-1	Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө /сая.төг/	6
Хүснэгт-2	Төсөвт өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээний мэдээлэл /сая.төг/	9
Хүснэгт-3	2025 онд олгосон санхүүжилт /сая.төг/	10
Хүснэгт-4	Төсөл, арга хэмжээний зураг төслийн өөрчлөлтийн мэдээлэл	12
Хүснэгт-5	Зохиолчийн хяналт хэрэгжүүлсэн байдал	15
Хүснэгт-6	ГХБХБГ-ын хэрэгжүүлсэн барилгын материал болон сорьцын шинжилгээ хийлгэсэн дээжийн тоо	18
Хүснэгт-7	Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан нөхцөл байдал	19
Хүснэгт-8	2025 онд гүйцэтгэсэн эзэмшигч тогтоосон хөрөнгийн жагсаалт	23
Хүснэгт-9	Өвөрхангай аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан ХО-ын төсөл арга хэмжээний хэрэгжилтийн үзүүлэлт	26
Хүснэгт-10	Аудитын шийдвэрийн судалгаа /сүүлийн 3 жилээр/	27

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг- 1	Эрүүл мэндийн төвийн барилга /Өвөрхангай, Хужирт сум/	13
Зураг-2	Татварын хэлтсийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Арвайхээр сум/	14
Зураг-3	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Өвөрхангай, Хархорин сум/	14
Зураг-4	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудас	20
Зураг-5	Шаардлага хангаагүй мэдээллийн самбарын зураг	22

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Барилгын тухай хууль, захиалагчийн хяналтын дүрмийн схем	17
Дүрслэл 2	Хууль тогтоомжийн схем	26

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт-1	Барьцаа хөрөнгийн данснаас олгосон 2024 оны санхүүжилт	28
Хавсралт-2	Төсөл арга хэмжээний эцсийн үлдэгдэл	29

Аудитын нэр:	Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт
Аудитын код:	ӨВА-2026/05-14-ШТА-НА
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/179 дүгээр тушаал, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, аудитын дэд төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	<p>Өвөрхангай аймагт хэрэгжүүлсэн улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх; ▪ Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх; ▪ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан, баримт материалыг хамруулав.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:</p>	<p>Аудитыг Өвөрхангай аймаг дах Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор О.Батжаргал удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер П.Хорлоосүрэн хэрэгжүүлж, Ахлах аудитор Б.Баяртогтох, аудитор Г.Нинжбадгар, Р.Цэрэндолгор нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын тайлангийн бүтэц:</p>	<p>Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт зөвлөмж, холбогдох байгууллагын санал хэсгээс бүрдсэн.</p>
<p>Хүндрэл бэрхшээл:</p>	<p>Аудитаар талбарт ажиллах төсөв хүрэлцээгүй, цаг хугацаа, хүн хүчний нөөц боломжтой холбоотой аудитын хамрах хүрээ багассан. Мөн эрсдэлтэй асуудлыг бүрэн хамруулж чадахгүй, аудитын дүгнэлт нь хэсэгчилсэн мэдээлэлд тулгуурлах, бодит байдлыг бүрэн илэрхийлэхгүй байх эрсдэл нэмэгдсэн.</p>



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд Өвөрхангай аймагт 11 сайдын багцад 315,957.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 132,488.2 сая төгрөгөөр санхүүжих 31 төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан байна.

Үүнээс 2022-2024 оны хөрөнгө оруулалтаар аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 2025 онд дамжин хэрэгжиж байгаа 89,744.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл, арга хэмжээ, эрх шилжиж ирээгүй 226,212.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 1. Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө /сая.төг/

Ангилал	Эрх шилжиж ирсэн			Эрх шилжиж ирээгүй					
	Шилжих ТАХ			Шинэ ТАХ			Шилжих ТАХ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга, байгууламж	16	63,730.7	24,302.2	2	3,718.2	987.3	1	1,398.2	449.2
Авто зам	2	7,411.7	2,176.4				3	155,402.6	71,902.1
Дэд бүтэц	2	18,601.9	6,709.5	2	24,001.0	7,128.6	2	30,909.8	9,620.6
ТЭЗҮ				1	10,783.1	9,212.3			
Нийт	20	89,744.3	33,188.1	5	38,502.2	17,328.2	6	187,710.6	81,971.8

Нийт санхүүжилтийн 19.4 хувийг 19 барилга, байгууламж, 55.9 хувийг 5 авто зам, 17.7 хувийг 6 инженерийн шугам, сүлжээ, 7.0 хувийг 1 ТЭЗҮ төсөл, арга хэмжээний санхүүжилтэд тус тус зарцуулахаар тусгасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2025 оны төлөвлөгөөнд тусгасан нийт 31 төсөл, арга хэмжээнээс 35.5 хувь буюу 11 төсөл, арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлж дуусгахаар, 64.5 хувь буюу 20 төсөл, арга хэмжээг дараагийн онуудад үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИЖ БУЙ ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙГЭЭС ШАЛТГААЛЖ ТӨЛӨВЛӨСӨН ХУГАЦААНД АШИГЛАЛТАД ОРООГҮЙ БАЙНА.

Аудитын дүн: Аудитаар нийт **7,800.7** сая төгрөгийн зөрчил илэрч **6** албан шаардлага, **3** зөвлөмж, **7,063.9** сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тоцов.

БҮЛЭГ 1. ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ 2025 ОНД ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ БАЙХГҮЙ БАЙНА.

Өвөрхангай аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд тусган, 315,957.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 132,488.2 сая төгрөгөөр санхүүжих 31 төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнээс өмнөх онуудаас буюу 2022-2024 оны дамжин хэрэгжиж байгаа 89,744.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл, арга хэмжээ, эрх шилжиж ирээгүй 226,212.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээ байна.

Өвөрхангай аймгийн Засаг дарга улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр 483,597.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 100 төсөл, арга хэмжээний жагсаалтыг 2024 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 1/368 дугаар албан бичгээр холбогдох яамдад хүргүүлсэн байна.

Үүнээс 5,260.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тайлант онд 1,386.5 сая төгрөгөөр санхүүжигдэж, 2025-2027 онд хэрэгжихээр “Сумын төвийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний ажил” /Өвөрхангай, Төгрөг сум/ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан ба аймгийн Засаг даргад эрх шилжээгүй байна.

Аймгийн Засаг даргаас хүргүүлсэн саналын 1.0 хувьтай тэнцэх төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байгаа нь аймаг, орон нутгийн нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, нийгэмд үзүүлэх эдийн засгийн үр дүнг бууруулж байна.

БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД 2025 ОНД ШИНЭЭР ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛЭЭГҮЙ ТУЛ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.

Өвөрхангай аймагт шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтад тусган, 38,502.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл арга хэмжээ баталсан байна. Гэвч эдгээр төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргад эрх шилжүүлээгүй тул худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

БҮЛЭГ 3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛСНААС ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ТӨЛӨВЛӨСӨН ХУГАЦААНД АШИГЛАЛТАД ОРООГҮЙ БАЙНА.

А.1. Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг зохиогчийн зөвшөөрөлгүй зураг төсөлд өөрчлөлт оруулж гүйцэтгэсэн байна.

А.1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нь нэмэгдсэнээс шалтгаалж гэрээний хугацаанд дуусаагүй байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтад тусгасан өмнөх оноос шилжин хэрэгжиж байгаа 89,744.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 20 төсөл, арга хэмжээнээс 18,634.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлж дуусгахаар баталсан байна.

Үүнээс 3 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаандаа хэрэгжүүлж, ашиглалтад хүлээлгэн өгсөн бол дараах 3 төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг сунгасан байна. Тодруулбал.

- **Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга, музейн танхим хамт /Өвөрхангай Есөнзүйл сум/-** Барилга угсралтын ажлын тоо хэмжээ дутуу зарлагдсан. Дутуу зарлагдсан ажлын тоо хэмжээний дагуу төсөвт өртгийг тооцон аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан 2026 оны улсын төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн ч санхүүжилт батлагдаагүй. Иймд алданги тооцон гэрээний хугацааг сунгасан байна.
- **Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Арвайхээр сум, 13 дугаар баг/-** Худалдан авах ажиллагааг зарлахдаа магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан ажлын тоо хэмжээнээс хасаж зарласан, зураг төслийн дагуу төсвийг боловсруулаагүй мөн төсөл, арга хэмжээний метр квадратын үнэлгээг алдаатай тооцсон зэргээс шалтгаалж төсвийг шинэчилж төсөв нэмэгдсэн. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд 267.1 сая төгрөгийн санхүүжилт тусгагдсан байна.
- **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/-** Барилга угсралтын ажлын төсөвт өртөг нь 7,919.2 сая төгрөг байсан боловч 2025 оны улсын төсөвт 4,209.3 сая төгрөг төлөвлөснөөс гадна инженерийн шугам сүлжээний ажлын тоо хэмжээг хасаж гэрээ байгуулсан байна. Барилгын төсөвт өртгийн үлдэгдэл 3,709.9 сая төгрөгийг 2026 оны улсын төсөвт баталж, тус ажлын тоо хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулж гэрээ байгуулах эрх олгосон байна.

Харин 2024 оноос дамжин хэрэгжиж байгаа 4 төсөл, арга хэмжээ 2025 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй орхигдсоноос дуусаагүй байна.

- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Богд сум/
- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Өвөрхангай, Бүрд сум, 5 дугаар баг/
- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Өвөрхангай, Зүүнбаян-Улаан сум, 3 дугаар баг/
- Музейн дотоод интерьер /Өвөрхангай, Арвайхээр сум/

Дээрх төсөл, арга хэмжээнүүдийн хувьд төлөвлөлтийн шаардлага хангаагүй, анх батлагдахдаа магадлалаар баталгаажсан төсвийн дүнд үндэслээгүй, батлагдсан төсөвт өртөгт багтаах зорилгоор барилга угсралтын ажлын тоо хэмжээг хэсэгчлэн салгаж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан, 2024 онд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжиж эхлээгүй зэргээс шалтгаалан 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдаагүй байна.

Мөн дээрх шалтгаанаар улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжиж эхэлсэн дараах 25,605.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэлд 2025 онд хийсэн аудитын дүгнэлтээр захиалагчаас ирүүлсэн төсвийн өөрчлөлтийн 10,020.2 сая төгрөгийг үндэслэлтэй гэж үзэн баталгаажуулж нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 2. Төсөвт өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээний мэдээлэл /сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг		Нэмэгдсэн төсөв
		Эхлэх	Дуусах	Анхны	Сүүлийн	
1	Дотуур байрны барилга, 100 ор /Өвөрхангай, Уянга сум, 2 дугаар сургууль/	2024	2026	2,924.20	3,413.40	489.20
2	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Сант сум/	2024	2026	2,770.80	2,931.50	160.70
3	Номын сан, урлаг заал бүхий сургуулийн барилгыг өргөтгөл 240 суудал /Өвөрхангай, Баянгол/	2024	2027	2,989.0	5,223.20	2,234.20
4	Спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Гучин-Ус сум/	2024	2026	2,840.50	3,181.80	341.30
5	Спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Уянга сум, 2 дугаар сургууль/	2024	2026	2,810.40	3,011.20	200.80
6	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Богд сум/	2024	2026	600.00	914.60	314.60
7	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Өвөрхангай, Бүрд сум, 5 дугаар баг/	2024	2026	600.00	854.10	254.10
8	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Өвөрхангай, Зүүнбаян-Улаан сум, 3 дугаар баг/	2024	2027	600.00	1,805.30	1,205.30
9	Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Арвайхээр сум, 13 дугаар баг/	2024	2027	4,261.60	4,795.80	534.20
10	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	2024	2027	4,209.3	7,919.20	3,709.90
11	Музейн дотоод интерьер /Өвөрхангай, Арвайхээр сум/	2024	2026	1,000.00	1,575.90	575.90
ДҮН				25,605.8	35,626.0	10,020.2

Эх үүсвэр: Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль, Нийцлийн аудитын тайлан

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаснаар хуульд баталсан төсөвт өртөг нэмэгдэж, улмаар төслийг гэрээний хугацаанд хэрэгжүүлэх боломж хязгаарлагдах, үр дүн саатах, гэрээний үүргийн биелэлт алдагдах, нөөцийн ашиглалтын үр ашиг буурах эрсдэл бий болсон байна.

Барилгын ажил зогсож царцсан дараах 2 төсөл, арга хэмжээ байна.

- **Аврах гал унтраах ангийн барилга /Өвөрхангай, Хархорин сум/** төсөл, арга хэмжээ нь 2022 оноос хэрэгжиж эхэлсэн ба гүйцэтгэгчээр Цагаанбургалтай ХХК шалгарч 2,989.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажлын зураг төсөв 2019 онд магадлалаар баталгаажсан тул барилгын материалын үнэ, тээврийн зардал, барилга угсралтын ажлын зардал нэмэгдэн дахин магадлал хийгдэх шаардлага үүссэн. Төсөв магадлалаар баталгаажуулах ажил удаашран, төсөв батлагдахгүй, барилгын ажлын гүйцэтгэл 80.0 хувьтай зогсонги байдалтай байна.
- **Сургуулийн барилгын урлаг заал, номын сан бүхий өргөтгөлийн барилга /Өвөрхангай, Уянга сум/** Тус төсөл, арга хэмжээ нь 2022 оноос эхэлж хэрэгжин СТНАА ХХК-ийн барилга угсралтын ажил дуусаж, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг хангаж комиссын дүгнэлтээ гаргуулаагүйгээс шалтгаалан ашиглалтад ороогүй байна.

Барилгын ажил гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ, хүлээлгэх хариуцлага болон гэрээ цуцлах, эрх зүйн зохицуулалт тодорхой бус, нарийвчилсан зохицуулалт хангалтгүй байна.

Захиалагч талаас гэрээ цуцлах нөхцөл, журам болон цуцалсны дараах ажлын шилжилт, санхүүгийн тооцоо, хариуцлага, шинэ гүйцэтгэгч сонгон шалгаруулах үйл явцын зохицуулалтыг тодорхой болгож сайжруулах шаардлагатай байна.

А.1.2. Тайлант онд төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн олгосон санхүүжилт 85.7 хувьтай байна.

Өмнөх оноос шилжин хэрэгжиж буй 20 төсөл, арга хэмжээнд 2025 онд 33,188.1 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 28,434.1 сая төгрөгийг олгож, санхүүжилтийн хэрэгжилт 85.7 хувьтай байна.

Хүснэг 3. 2025 онд олгосон санхүүжилт /сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	2025 онд олгосон санхүүжилт
		Эхлэх	Дуусах			
1	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга, музейн танхим хамт /Өвөрхангай Есөнзүйл сум/	2024	2025	2,390.3	1,163.3	924.3
2	Татварын хэлтсийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Арвайхээр сум/	2024	2025	1,150.0	509.9	509.9
3	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга /Өвөрхангай Арвайхээр сум/	2024	2026	2,502.7	869.5	869.5
4	Дотуур байрны барилга, 100 ор /Өвөрхангай, Уянга сум, 2 дугаар сургууль/	2024	2026	2,924.2	1,023.1	1,023.1
5	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Сант сум/	2024	2026	2,770.8	917.9	917.9
6	Номын сан, урлаг заал бүхий сургуулийн барилгыг өргөтгөл 240 суудал /Өвөрхангай, Баянгол/	2024	2026	2,989.0	1,039.0	1,039.0
7	Спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Гучин-Ус сум/	2024	2026	2,840.5	988.0	519.0
8	Спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Уянга сум, 2 дугаар сургууль/	2024	2026	2,810.4	1,812.7	1,305.4
9	Сургуулийн барилга, 320 суудал /Өвөрхангай, Хархорин сум/	2024	2026	7,368.5	2,647.0	2,647.0
10	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Өвөрхангай, Баян-Өндөр сум, 5 дугаар баг/	2024	2026	8,470.1	2,945.1	2,945.1
11	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Өвөрхангай, Арвайхээр сум, 2 дугаар сургууль/	2024	2026	7,500.3	2,844.3	2,844.3
12	Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Арвайхээр сум, 13 дугаар баг/	2024	2025	4,261.6	2,130.8	2,130.8
13	Хүүхэд, залуучуудын хөгжлийн ордны барилга /Өвөрхангай Хархорин сум/	2024	2026	4,890.0	1,640.0	1,640.0
14	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	2024	2025	4,209.3	2,104.7	2,104.7
15	А0302 авто замаас Хайрхандулаан сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 3.2 км /Өвөрхангай, Хайрхандулаан сум/	2024	2025	2,672.7	517.8	517.7
16	Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Өвөрхангай, Арвайхээр, Хархорин, Хужирт сум/	2024	2026	1,752.1	548.4	548.4
	Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Өвөрхангай, Арвайхээр, Хархорин, Хужирт сум/	2024	2026	1,516.0	548.4	548.4
	Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Өвөрхангай, Арвайхээр, Хархорин, Хужирт сум/	2024	2026	1,470.9	561.8	561.8
17	Соёлын төвийн барилга, 400 суудал /Өвөрхангай, Хужирт сум/	2022	2025	3,950.4	727.1	727.1
18	Соёлын төвийн барилга, 250 суудал /Өвөрхангай, Төгрөг сум, 1 дүгээр баг/	2024	2026	2,702.6	939.8	-

19	Сумын инженерийн шугам сүлжээний шинэчлэл /Өвөрхангай, Нарийнтээл сум/	2024	2026	5,973.8	2,523.8	2,523.8
20	Гэр хорооллын шугам сүлжээ /Өвөрхангай, Арвайхээр сум/	2024	2026	2,869.4	1,000.0	-
	Гэр хорооллын шугам сүлжээ /Өвөрхангай, Арвайхээр сум/	2024	2026	5,977.6	1,261.2	519.1
	Гэр хорооллын шугам сүлжээ /Өвөрхангай, Арвайхээр сум/	2024	2026	3,781.1	1,924.5	1,067.9
ДҮН				89,744.3	33,188.1	28,434.2

Эх сурвалж: СТСХ-ын судалгаа, дансны хууль

Дараах 5 төсөл, арга хэмжээний нийт 4,753.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч чадаагүй байна. Үүнд:

- Соёлын төвийн барилга, 250 суудал /Өвөрхангай, Төгрөг сум, 1 дүгээр баг/, Санхүүжилтийн гүйцэтгэлийг оны сүүлд баталгаажуулсан боловч гүйлгээ хийж амжаагүй төвлөрүүлсэн байна.
- Гэр хорооллын шугам сүлжээ /Өвөрхангай, Арвайхээр сумын 3, 8 дугаар багийн шугам сүлжээ/-Ажил гүйцэтгэх явцад хөрсний зэрэглэл зөрсөн учир төсөв нэмэгдүүлэх албан бичиг захиалагчид хүргүүлсэн, 2025 онд ажлын гүйцэтгэлээр санхүүжилт дутуу авсан.
- Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга, музейн танхим хамт /Өвөрхангай Есөнзүйл сум/- Барилгын ажлын гүйцэтгэлээр баталгаажуулан, 239.0 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан.
- Спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Гучин-Ус сум/- Ажлын гүйцэтгэлээр баталгаажуулан 469.0 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан.
- Спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Уянга сум, 2 дугаар сургууль/- Барилгын ажлын гүйцэтгэлээр баталгаажуулан, санхүүжилтийг 507.3 сая төгрөгөөр дутуу авсан.

Цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтыг бүрэн, үр ашигтай ашиглах, төлөвлөсөн ажлыг хугацаанд нь гүйцэтгэхэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж, зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

Монгол улсын Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолын дагуу 2025 онд барьцаа хөрөнгийн данснаас 12 төсөл арга, хэмжээний гүйцэтгэгчид 2024 оны үлдэгдэл 8,859.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгоходоо 444.5 сая төгрөгийг чанарын баталгаанд, 45.8 сая төгрөгийн алданги суутган тооцжээ. /Хавсралт 1/

Тайлант хугацаанд гэрээний үүргийг хэрэгжүүлээгүй байхад санхүүжилт бодит гүйцэтгэлээс илүү олгогдсон дараах төсөл, арга хэмжээнүүд байна.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Өвөрхангай, Хужирт сум/ төсөл, арга хэмжээний 2024 оны ажлын гүйцэтгэлийг 32.7 хувь буюу 479.9 сая төгрөг, 2025 оны гүйцэтгэлийг 38.3 хувь буюу 561.8 сая төгрөг, нийт 71.0 хувиар баталгаажуулан Анда рөүд ХХК-д олгосон. Ажлын гүйцэтгэлийг талбарт тулган баталгаажуулалт хийж, хийгдээгүй замын хучилт, тоноглол, тэмдэглэгээний ажил, явган хүний замын ажил, авто замын гэрэлтүүлгийн ажлуудыг ажлын тоо хэмжээгээр төсөвт өртгийг тооцоолоход 261.9 сая төгрөгийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон зөрчил илэрсэн.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/ төсөл арга хэмжээний 10.0*10.0 хэмжээтэй 2 автомашины дулаан зогсоолыг гүйцэтгээгүй байхад захиалагчийн хяналтын тайлан, хурлын тэмдэглэл, санхүүжилтийн маягтад барилга угсралтын гэрээт ажлын тоо хэмжээний дагуу бүрэн хийгдсэн гэж

баталгаажуулан, санхүүжилтийг 100.0 хувь Юу зэт эрдэнэ ХХК-д олгосон зөрчил илэрсэн.

Дээрх 2 зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5.1.2¹, 5.1.5², 6.4.1³, 41.2.3⁴, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.1.6⁵, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.16⁶-т заасныг тус тус зөрчсөн. Энэ нь Төсвийн тухай хуулийн үр ашиг, хэмнэлттэй байдлыг хангах зарчим алдагдах, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, зорилтот үр дүнд хүрэх санхүүгийн болон захиргааны чадамжийг бууруулах, улмаар төрд эдийн засгийн хохирол учруулах нөхцөл байдлыг бүрдүүлсэн байна.

Иймд дээрх 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг магадлалаар баталгаажсан болон гэрээний нэгж үнийн төсөв, ил, далд ажлын акт, фото баримтад үндэслэн бодитоор дахин баталгаажуулж, гүйцэтгэгчид илүү олгосон санхүүжилтийг дараагийн гүйцэтгэлээс суутган зөрчлийг арилгуулах албан шаардлагыг аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын ХБТХОХ, СТСХ-т хүргүүллээ.

А.1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим төсөл, арга хэмжээг зохиогчийн зөвшөөрөлгүй зураг төсөлд өөрчлөлт оруулж гүйцэтгэсэн байна.

Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-т “Барилга байгууламж нь зураг төслийн дагуу баригдсан байх шаардлагыг хангасан байна”, 37 дугаар зүйлийн 4-т “Захиалагч барилга байгууламжийн зураг төслийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно” гэж заасан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсөвт хяналт тавьж гүйцэтгүүлсэн боловч дараах төсөл, арга хэмжээ нь зураг, төсвийн дагуу хийгдээгүй, зураг төслийн өөрчлөлтөд зохиогчийн зөвшөөрөл авахаар хүсэлт хүргүүлсэн боловч хариу хүргүүлээгүй байна. Тухайлбал:

Хүснэгт 4. Төсөл, арга хэмжээний зураг төслийн өөрчлөлтийн мэдээлэл

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч	Зураг төсвийн өөрчлөлт
1	Гэр хорооллын шугам сүлжээ /Арвайхээр сумын 1, 9 дүгээр багийн шугам сүлжээ/	"Хангайн илч дулаан" ХХК Гүйцэтгэл: 54 хувь	БХ-93, БХ-94, БХ-95, БХ-96, БХ-97 худгуудад 1500 мм хэмжээтэй бетон цагариг хийх байсныг 1000 мм хэмжээтэй цагариг хийсэн.
2	Гэр хорооллын шугам сүлжээ /Өвөрхангай, Арвайхээр сум/	"Гуа-Орд" ХХК Гүйцэтгэл: 90 хувь	БХ-74, БХ-75, БХ-76, БХ-77, БХ-78 худгуудын гүн зураг төслөөс 30-50 см ээр зөрүүтэй нам хийсэн.
3	Сургуулийн барилга, 320 суудал /Хархорин сум/	"Хангай-Энержи" ХХК Гүйцэтгэл: хувь	Сургуулийн барилгын Г хэлбэр эсрэг талдаа байхаар өөрчлөлт оруулсан, гадна тохижилтын зураг өөрчлөгдсөн.
4	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Баян-Өндөр сум, 5 дугаар баг/	"Тэд констракшн" ХХК Гүйцэтгэл: 85 хувь	Сургуулийн барилгын хүзүүвч хэсгийн байршил өөрчлөгдсөн.
5	Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга, 150 ор /Арвайхээр сум/	"Оазислэнд констракшн" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Ашиглагчийн хүсэлтээр авто машины дулаан зогсоолын байршил өөрчлөгдсөн.

¹ 5.1.2 “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”

² 5.1.5 “хариуцлагатай байх”

³ 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”

⁴ 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”

⁵ 2.1.6 “Хууль, журмын шаардлага хангасан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийн эрхийг нээх, шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг олгохгүй байх”.

⁶ 3.16 “Барилгын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, чанаргүй, дутуу гүйцэтгэсэн, захиалагч болон эрх бүхий байгууллагын шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд захиалагч барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахгүй. Энэ тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч болон хөрөнөө оруулагч санхүүжилт олгохгүй байж болно”

Хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний батлагдсан зураг төслийг зохиогчийн зөвшөөрөлгүй өөрчилсөн нь барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс ажиллах үед татгалзах үндэслэл болох, зураг төсөл өөрчилснөөс үүдэн ирээдүйд гарч болох эвдрэл, гэмтэлд хэн хариуцлага хүлээх нь тодорхойгүй болох зэрэг эрсдэл үүсэх нөхцөл бүрдүүлж байна.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, авто замыг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн эсэхийг барилгын ажлын талбар дээр очиж үзэхэд дараах байдалтай байна.

- Эрүүл мэндийн төвийн барилга /Өвөрхангай, Хужирт сум/ - тай барилгын ажлыг Воконконтрашн ХХК гүйцэтгэж, байнгын ашиглалтад хүлээн авсан. Комиссын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, гадна тохижилтын ажил дутуу, ашиглалтын явцад паркетан шалны завсар гарч ангайсан, Төрөх өрөөний вакуум хаалтын чигжээс хөөс ил гарсан, эрүүл ахуйн шаардлага хангаагүй байна.
- Татварын хэлтсийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Арвайхээр сум/- ажлыг Цаст Тэргүүн Констракшн ХХК гүйцэтгэж 2025 оны 7 дугаар сард ашиглалтад оруулсан. Барилгыг ашиглалтад хүлээн авах комиссын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, дээврээс ус гоожсон, дотор хана хагаралт ихтэй, шилэн фасадтай хэсгийн дотор талд, дээд хэсгээр шилэн хөвөн ил гарсан, эрүүл ахуйн шаардлага хангахгүй байсан;

Зураг 1. Эрүүл мэндийн төвийн барилга /Өвөрхангай, Хужирт сум/



Зураг 2. Татварын хэлтсийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Арвайхээр сум/



! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Дээрх 2,858.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 2 барилга байгууламжийн гүйцэтгэсэн зарим ажлуудад гүйцэтгэгч барилгын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн зөрчил илэрсэн.

Сайн жишээ: Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Өвөрхангай, Хархорин сум/ нь орчин үеийн жишигт нийцсэн, дизайн шийдэлтэй, эмнэлгийн зориулалтын стандарт шаардлагад бүрэн нийцсэн байна.

Тус барилга ашиглалтад орсноор үйлчлүүлэгчид, эмч, эмнэлгийн ажилтнуудад аюулгүй, тав тухтай орчин бүрдэж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна. Мөн иргэд орон нутагтаа чанартай оношилгоо, эмчилгээ хийлгэх боломж нэмэгдэж, дээд шатлалын эмнэлэгт хандах ачаалал буурах нөхцөл бүрджээ.

Зураг 3. Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Өвөрхангай, Хархорин сум/



А.1.4. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээ дүгнэх маягтаар баталгаажуулж ажилласан байна.

Улсын комиссын актаар хүлээн авсан 11, төсөв нэмэгдсэнтэй холбоотой нэмэлт гэрээ байгуулж буй 7 төсөл, арга хэмжээний эцсийн санхүүжилтийг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.28⁷, 4.8.29⁸-д заасны дагуу барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хяналтын хуудас, гүйцэтгэлийн төсвийг үндэслэн захиалагч “Гэрээ дүгнэх маяг”-аар баталгаажуулж олгосон байна.

Гэрээний гүйцэтгэлийг дүгнэж, чанарын баталгаанд 1,278.1 сая, төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

А.2. Комиссын гишүүдийн үүрэг даалгаврыг бүрэн биелүүлээгүй, гэрээнд заасан ажлыг гүйцэтгээгүй байхад комиссын дүгнэлт гарган барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авсан байна.

А.2.1. Авто замын ажлын хувьд захиалагч болон зохиогчийн хяналтын гэрээ байгуулаагүй нь авто зам, замын байгууламжийн ажил чанаргүй хийгдэх эрсдэлтэй байна.

Аймгийн ГХБХБГ-ын Барилга, хот байгуулалтын хэлтсээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 23 барилга байгууламж, инженерийн шугамын ажилд тухай бүр захиалагчийн хяналт хэрэгжүүлж, хяналтын явцын дүгнэлт гарган баталгаажуулж, ил далд ажлын акт үйлдэж, фото зургаар баримтжуулан ажлын гүйцэтгэлд хавсаргасан байна.

Харин дараах 17 төсөл, арга хэмжээнд зохиогчийн хяналтыг үе шат тухай бүрд хийгээгүй, зарим үед цахимаар зохион байгуулах, ил, далд ажлын актыг баталгаажуулаагүй зэрэг зөрчил илэрсэн.

Хүснэгт 5. Зохиолчийн хяналт хэрэгжүүлсэн байдал

№	Төсөл, арга хэмжээний нэр	Зохиогчийн хяналт		
		Хэрэгжүүлэгч	Хяналт хийх тоо	Хяналт хийсэн тоо
1	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Өвөрхангай, Арвайхээр сум, 2 дугаар сургууль/	Зэдпроект	14	5
2	Татварын хэлтсийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Арвайхээр сум/	Арвайпроект	хуваарь байхгүй	1
3	Дотуур байрны барилга, 100 ор /Өвөрхангай, Уянга сум, 2 дугаар сургууль/	Төгс гранд констракшн	17	2
4	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Сант сум/	Төгс гранд констракшн	15	2
5	Сургуулийн барилга, 320 суудал /Өвөрхангай, Хархорин сум/	Би Зэт прожект групп	14	3
6	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга, музейн танхимын хамт /Өвөрхангай, Есөнзүйл сум/	Урбанвижн	7	3
7	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	Энхийн жаргал констракшн	12	3
8	Номын сан, урлаг заал бүхий сургуулийн барилгын өргөтгөл, 240 суудал /Өвөрхангай, Баянгол сум/	Артконстракшн	17	4
9	Спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Гучин-Ус сум/	Төгс гранд констракшн	14	3
10	Спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Уянга сум, 2 дугаар сургууль/	Төгс гранд констракшн	17	-
11	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Өвөрхангай, Баян-Өндөр сум, 5 дугаар баг/	Зэдпроект	14	6

⁷ Захиалагч нь барилга байгууламж, их засварын ажил, тоног төхөөрөмж худалдан авах, зөвлөх үйлчилгээ болон худалдан авах төсөл зэрэг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ тус бүрийн хяналтын хуудсыг энэ журмын хавсралтад заасан холбогдох маягтын дагуу бөглөж, баталгаажуулан ирүүлнэ.

⁸ Төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлтэд гэрээг дүгнэсэн байх бөгөөд энэ журмын 16 дугаар хавсралтад заасан “Гэрээ дүгнэх маяг”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд эх хувиар хавсаргаж ирүүлнэ.

12	Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Арвайхээр сум, 13 дугаар баг/	ОСИБЗТ	11	4
13	Хүүхэд залуучуудын хөгжлийн ордны барилга /Өвөрхангай, Хархорин сум/	Төгс гранд констракшн	17	5
14	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	Жаргалантхийц	9	7
15	Соёлын төвийн барилга, 250 суудал /Өвөрхангай, Төгрөг сум, 1 дүгээр баг/	Би Зэт прожект групп	14	1
16	Сумын инженерийн шугам сүлжээний шинэчлэл /Өвөрхангай, Нарийнтээл сум/	Инжбайгууламж	7	2
17	Гэр хорооллын шугам сүлжээ /Өвөрхангай, Арвайхээр сум/ 3.8	Инжбайгууламж	9	3
	Гэр хорооллын шугам сүлжээ /Өвөрхангай, Арвайхээр сум/ 1.9	Инжбайгууламж	9	2
	Гэр хорооллын шугам сүлжээ /Өвөрхангай, Арвайхээр сум/	Инжбайгууламж	9	3
	Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Хужирт сум/	Ихэрмөнх	гэрээ байхгүй	хяналт байхгүй
НИЙТ			226	59

Эх үүсвэр: Зохиогчийн хяналтын гэрээ, зохиогчийн хяналтын тайлан

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 17 төсөл, арга хэмжээний зохиогчийн хяналтын гэрээнд барилгын ажлын үе шат бүрд 226 удаа биечлэн очиж хяналт хийхээр тусгасан боловч 59 удаагийн хяналт хийсэн байгаа нь гүйцэтгэгч компани үе шатны ажлыг зураг, төсвийн дагуу хийгдэхгүй байх эрсдэл үүсэж байна.

Иймд Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажилд зураг төсөв зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.2⁹-т заасны дагуу зохиогчийн хяналтыг гэрээний дагуу гүйцэтгэж, тайлагнах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн өмнөх оноос шилжин хэрэгжих 20 төсөл, арга хэмжээний зохиогчийн хяналтын зардалд 2025 онд 201.0 сая төгрөгийг олгожээ.

Авто зам, замын байгууламжийн хувьд зохиогч болон захиалагчийн хяналтын талаар Авто замын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1¹⁰, “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт хийх дүрэм”-ийн 3.1¹¹-т заасны дагуу эрх бүхий мэргэжлийн байгууллага захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлэхээр заажээ. Гэвч Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Арвайхээр, Хархорин, Хужирт сум/-ын ажлын хувьд захиалагч болон зохиогчийн хяналтын гэрээ байгуулаагүй нь авто зам, замын байгууламжийн ажил чанаргүй хийгдэх эрсдэлтэй байна.

Зохиогчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байгаа нь хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний чанар, үр дүнд нөлөөлсөн байгаа ба захиалагч, зохиогч болон бусад хяналтыг чанартай хэрэгжүүлж, гэрээний үүргийн биелэлтийг хангуулснаар хөрөнгө оруулалтын чанар, үр дүнг нэмэгдүүлэх боломж байна.

⁹ Зохиогчийн хяналтыг барилга байгууламжийн байршил, онцлогоос хамааруулан дараах 3 хэлбэрээр гүйцэтгэнэ.

3.2.1.барилгын ажилд байнгын хяналт тавих;

3.2.2.тогтмол хуваарийн дагуу барилгын ажилд хяналт тавих

3.2.3.барилгын ажлын үе шат бүрд хяналт тавих.

¹⁰ 21.1.Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг эрх бүхий мэргэжлийн байгууллага захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

¹¹ 3.1.Зураг төсөл зохиогч барилгын ажлын захиалагчтай / цаашид захиалагч гэх/ гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина.

А.2.2. Барилгын материал, хийц, бүтээцийн эрүүл ахуйн шаардлагыг лабораторийн шинжилгээ, дүгнэлтээр баталгаажуулж, хяналт хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Барилгын тухай хууль, захиалагчийн хяналтын дүрэмд зааснаар барилгын материал, бүтээгдэхүүнд тавигдах шаардлага, хяналт, чиг үүргийн талаар дараах дүрслэлээр харуулав.

Дүрслэл 1. Барилгын тухай хууль, захиалагчийн хяналтын дүрмийн схем

Барилгын материал, бүтээгдэхүүнд тавих шаардлага


13.1. Барилга байгууламжид ашиглах барилгын материал, бүтээгдэхүүн дараах шаардлагыг хангасан байна:

13.1.1. барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, зураг төслийн шаардлагыг бүрэн хангасан байх;

13.1.2. хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй байх;

13.1.3. чанарыг баталгаажуулсан гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн батламжтай байх;

13.1.4. чанарын шаардлага хангасан зориулалтын сав, баглаа, боодол, хаяг, шошготой байх.



Эх сурвалж: Барилгын тухай хууль, захиалагчийн хяналтын дүрэм

Дээрх чиг үүргийн дагуу хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн хийц, бүтээцийн бетоны бат бэхийг шалгах, барилгын материалыг лабораторийн шинжилгээнд хамруулах талаар гүйцэтгэгч, захиалагч, зохиогчийн хяналтаар дараах үүрэг даалгаврыг өгч, биелэлтийг хангуулан ажилласан байна.

- Аймгийн ГХБХБГ-ын барилгын лабораторид хайрга, дайрга, элс, тоосго, хөнгөн бетон(блок), бетон, хөөсөн полистрал, явган замын хавтан, үл эвдэх зэрэг 15 төрлийн барилгын материалд нийт давхардсан тоогоор 188 ширхэг үзүүлэлтээр сорилт шинжилгээнүүдийг хийж, холбогдох дүгнэлтийг гаргасан байна.
- Өвөрхангай аймгийн хэмжээнд 2025 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа барилга угсралт, шугам сүлжээний ажлуудад нийт 1278 ширхэг сорьц дээжийг лабораторийн шинжилгээнд хамруулсан байна.

Тус лабораторийн барилга байгууламжийн материалын дээжид шинжилгээ хийсэн талаарх мэдээллийг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 6. ГХБХБГ-ын хэрэгжүүлсэн барилгын материал болон бетоны сорьцын шинжилгээ хийлгэсэн дээжийн тоо

№	Сорьцын төрөл	Нийт дээжийн тоо
1	Бетон сорьц	960
2	Дайрга CRS	10
3	Элс SA	7
4	Цемент	4
5	Полистрол хөнгөн блок BI	9
6	Явган замын хавтан TI	6
7	Хөөс Po	7
8	Керамик тоосго	5
9	Бетоны үл эвдэх	266
10	Бетон зуурмагийн температур	1
11	Бетон зуурмагийн конусын суулт	1
12	Элс хайрганы холимог	2
	Нийт дүн	1278

Эх үүсвэр: ГХБХБГ-ын барилгын материалын итгэмжлэгдсэн лабораторийн сорилт, шинжилгээний дүн

Барилгын тухай хуульд барилгын материал, бүтээгдэхүүнд тавих шаардлагад хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй байхаар зааснаас гадна Эрүүл ахуйн тухай хуульд хот суурин газрын төлөвлөлт, барилга байгууламж нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн, эрүүл ахуйн нөхцөл, барилгын норм, нормативын шаардлагыг хангасан байна гэж заажээ.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар захиалагч болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх явцад барилгын гүйцэтгэгч нь барилга, байгууламжид ашигласан материал, хийц, бүтээцийн эрүүл ахуйн шаардлага хангасан эсэхийг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулж, холбогдох дүгнэлт гаргуулсан эсэхэд хяналт тавьсан нь нотлогдохгүй байна.

Иймд цаашид хяналтыг сайжруулах, барилга байгууламжид хэрэглэсэн барилгын материал, хийц, бүтээцийн үзүүлэлтэд эрүүл ахуйн шаардлагыг сорилт, шинжилгээний итгэмжлэгдсэн лабораториор сар, улирал тутамд тодорхойлуулж ажиллах шаардлагатай байна.

Эрүүл ахуйн чанар, стандартын шаардлага хангаагүй барилгын материал нь барилга, байгууламжийн дотоод орчны эрүүл ахуйн нөхцөл алдагдах, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна.

А.2.3. Комиссын гишүүдийн үүрэг даалгаврыг бүрэн биелүүлээгүй, гэрээнд заасан ажлыг гүйцэтгээгүй байхад комиссын дүгнэлт гарган барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авсан байна.

Өвөрхангай аймгийн хэмжээнд 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 34,645.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 барилга, байгууламжийг ашиглалтад оруулж хүлээн авсан байна.

Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах тухай дүрэмд ашиглалтад оруулах комисс нь хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг бүрэн хангуулж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлсний үндсэн дээр барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргахаар заасан.

Аудитаар дараах 10 төсөл, арга хэмжээний барилга байгууламж ашиглалтад оруулах комисс нь зураг төсөлд заасан ажлыг бүрэн гүйцэтгээгүй, холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангаагүй, гэрээнд тусгагдсан ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй, үүрэг даалгаврын биелэлтийг дүгнээгүй, үүрэг даалгавар бүрэн хэрэгжээгүй, нийт 94 зөрчлийг арилгаагүй байхад барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авчээ.

Хүснэгт 7. Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан нөхцөл байдал

№	Төсөл арга хэмжээний нэр	Ашиглалтад хүлээн авсан байдал
1	Сургуулийн барилга, 320 суудал /Хархорин сум/ Гүйцэтгэгч: Хангай энерги ХХК Гүйцэтгэл: 91.0 хувь	Төсөл, арга хэмжээ нь 7,368.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, ажлын гүйцэтгэл 91.0 хувьтай, гадна тохижилтын ажлын хэмжээнээс 736.8 сая төгрөгийн ажил гүйцэтгээгүй байхад 2025 оны 12 дугаар 18-ны өдрийн ББКД-62-0028/25 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан байна.
2	Татварын хэлтсийн барилгын өргөтгөл /Арвайхээр сум/ Гүйцэтгэгч: "Цаст Тэргүүн Констракшн" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Дулааны худаг доторх шугамын дулаалга хийх, гонхны дэврээс үс гоожсоныг засах зэрэг үүрэг даалгавар биелээгүй байхад барилгыг 2025.07.03-ны ББКД-62-0008/25 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулах шийдвэр гаргасан байна.
3	Дотуур байрны барилга, 100 ор /Уянга сум/ Гүйцэтгэгч: "Дүүрэнцацрах" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Комиссын гишүүдийн өгсөн 11 үүрэг даалгавар биелээгүй байхад барилгыг 2026.01.20-ны ББКД-62-0006/26 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулах шийдвэр гаргасан байна.
4	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Сант сум/ Гүйцэтгэгч: "Баяндөхөмийн хурд" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Комиссын гишүүдийн өгсөн 14 үүрэг даалгавар биелээгүй байхад барилгыг 2026.01.13-ны ББКД-62-0001/26 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулах шийдвэр гаргасан байна.
5	Соёлын төвийн барилга /Өвөрхангай, Баруунбаян-Улаан сум/ Гүйцэтгэгч: "Ти Эл Жи" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Комиссын гишүүдийн өгсөн 11 үүрэг даалгавар биелээгүй байхад дулааны улиралд хийхээр үүрэг даалгавар өгч 2025.12.25-ны ББКД-62-0024/25 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулах шийдвэр гаргасан байна.
6	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Хужирт сум/ Гүйцэтгэгч: "Вокомконстракшн" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Комиссын гишүүдийн өгсөн 26 үүрэг даалгавар биелээгүй байхад дулааны улиралд хийхээр үүрэг даалгавар өгч 2025.12.23-ны ББКД-62-0023/25 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулах шийдвэр гаргасан байна.
7	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Хархорин сум/ Гүйцэтгэгч: "Би энд Би Констракшн" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Комиссын гишүүдийн өгсөн 10 үүрэг даалгавар биелээгүй байхад 2025.12.23-ны ББКД-62-0022/25 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулах шийдвэр гаргасан байна.
8	Эрүүл мэндийн төвийн барилга /Өвөрхангай, Зүүнбаян-Улаан сум/ Гүйцэтгэгч: "Итгэлт-Өргөө" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Комиссын гишүүдийн өгсөн 1 үүрэг даалгавар биелээгүй, комиссын зарим гишүүд үүрэг даалгаврын биелэлтээ хянаагүй байхад 2025.10.28-ны ББКД-62-0013/25 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулах шийдвэр гаргасан байна.
9	Эрүүл мэндийн төвийн барилга /Өвөрхангай, Өлзийт сум/ Гүйцэтгэгч: "Галбын тос" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Комиссын гишүүдийн өгсөн 3 үүрэг даалгавар биелээгүй, комиссын зарим гишүүд үүрэг даалгаврын биелэлтээ хянаагүй байхад 2025.12.08-ны ББКД-62-0021/25 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулах шийдвэр гаргасан байна.
10	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Баруунбаян-Улаан сум/ Гүйцэтгэгч: "Пүүлүүбумба" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Комиссын гишүүдийн өгсөн 16 үүрэг даалгавар биелээгүй, комиссын зарим гишүүд үүрэг даалгаврын биелэлтээ хянаагүй байхад 2025.11.24-ны ББКД-62-0018/25 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулах шийдвэр гаргасан байна.

Үүрэг, даалгаврын хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийн дийлэнх нь гадна тохижилтын ажлыг дулааны улиралд гүйцэтгэх шинж чанартай ажилд хамаарч байна гэж дүгнэж, ашиглалтад хүлээн авсан байна.

Зураг 4. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудас

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС		БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС	
(Ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн хамт хүчинтэй)		(Ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн хамт хүчинтэй)	
Барилга байгууламжийн нэр, хүчин чадал: <i>Өвөрхангай, Хэнтийн сум, 2003 оны 11.06</i>		Барилга байгууламжийн нэр, хүчин чадал: <i>Хэнтийн сум, 2003 оны 11.06</i>	
Комиссын гишүүн нэр, утасны дугаар: <i>О. Ариунбаяр 77223750</i>		Комиссын гишүүн нэр, утасны дугаар: <i>О. Ариунбаяр 77223750</i>	
Харьяалагдах байгууллага, албан тушаал: <i>ТЭХБГ, барилга зорио</i>		Харьяалагдах байгууллага, албан тушаал: <i>ТЭХБГ, барилга зорио</i>	
Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар	Биелэлт	Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар	Биелэлт
<i>- Гарын үсгийн, тэмдэгт, хатуу, савнаа</i> <i>- Барилга хэргийн гүйцэтгэл, барилга зорио</i> <i>- Барилга зорио, барилга зорио</i>	<i>Барилгын ажлын гүйцэтгэл, барилга зорио</i>	<i>1. Барилгын ажлын гүйцэтгэл, барилга зорио</i> <i>2. Барилгын ажлын гүйцэтгэл, барилга зорио</i> <i>3. Барилгын ажлын гүйцэтгэл, барилга зорио</i> <i>4. Барилгын ажлын гүйцэтгэл, барилга зорио</i>	<i>Барилгын ажлын гүйцэтгэл, барилга зорио</i>
Үүрэг даалгавар өгсөн: <i>О. Ариунбаяр</i>	Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: <i>О. Ариунбаяр</i>	Үүрэг даалгавар өгсөн: <i>О. Ариунбаяр</i>	Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: <i>О. Ариунбаяр</i>
Гарын үсэг: <i>О. Ариунбаяр</i>	Гарын үсэг: <i>О. Ариунбаяр</i>	Гарын үсэг: <i>О. Ариунбаяр</i>	Гарын үсэг: <i>О. Ариунбаяр</i>
Тамга, тэмдэг: <i>О. Ариунбаяр</i>	Тамга, тэмдэг: <i>О. Ариунбаяр</i>	Тамга, тэмдэг: <i>О. Ариунбаяр</i>	Тамга, тэмдэг: <i>О. Ариунбаяр</i>
Огноо: <i>2023. 11.06</i>	Огноо: <i>2023. 12. 08</i>	Огноо: <i>2023. 11.06</i>	Огноо: <i>2023. 12. 08</i>

Үүний улмаас зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд чанаргүй гүйцэтгэсэн ажлыг хуульд заасны дагуу бүрэн засварлах үүргээ хэрэгжүүлэхгүй орхих нөхцөлийг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын ажлын үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Иймд ажлын хуваарьт улирлын нөлөөллийг нарийвчлан тооцож, ажлын үе шат, хугацааг бодитой тогтоох, захиалагчийн хяналтын явцад гүйцэтгэлийн хугацааг тооцоолж гүйцэтгүүлэх, комисс ажиллах хугацааг төлөвлөх шаардлагатай байна.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Дээрх 10 барилга байгууламжийг зураг төсөлд заасан ажлыг бүрэн гүйцэтгээгүй, холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангаагүй, гэрээнд тусгагдсан ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй, комиссын гишүүд үүрэг даалгаврын биелэлтийг дүгнээгүй, үүрэг даалгавар бүрэн хэрэгжээгүй, зөрчлийг арилгаагүй байхад барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авсан зөрчилд аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүлээ.

Дээрх зөрчил нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6¹², 48 дугаар зүйлийн 48.1¹³, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан

¹² 37.1.6 “энэ хуулийн 48.1-д заасны дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах”,
¹³ 48.1 “Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна”

"Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 8.1¹⁴, 8.2.1¹⁵ дэх заалтыг зөрчсөн байна.

A.2.4. Төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулсан эсэхэд захиалагч хяналт хэрэгжүүлээгүй байна.

Захиалагч нь "Улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжих бүтээн байгуулалтын ажлын мэдээллийн самбарт тавих шаардлага" Монгол Улсын үндэсний стандарт MNS 7023:2023-д заасны дагуу мэдээллийг иж бүрэн, ил тод, нээлттэй байршуулах үүргийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд хүлээнэ. Үүнд:

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2. хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, нээлттэй байх;
- Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4. Барилга байгууламжийн зураг төсөл, байр зүйн дэвсгэр зураг зэрэг мэдээлэл нийтэд нээлттэй, ил тод байна. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 18.1-д заасан мэдээлэл үүнд хамаарахгүй,
- Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн /Захиалагчийн чиг үүрэг/ 37.1.2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6.10, 8.6.11-д заасны дагуу барилга байгууламж болон үйл ажиллагааныхаа талаарх иж бүрэн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт нийтэд ил тод байрлуулах;

Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж, хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг байршуулсан эсэх, самбарт тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан үзэхэд дараах шаардлагуудыг хангаагүй байсан.

- Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/ огт байршуулаагүй;
- Ихэнх төсөл, арга хэмжээний самбарт захиалагч, гүйцэтгэгч байгууллагын утасны дугаар, талбайн инженерийн утасны дугаарыг мэдээлээгүй;
- Самбарын тулгуур металл багана байх, Гадна тохижилтын ажлын самбарыг төслийн гадна нүүрэн талд нийтэд харагдахаар, дээд тал нь 3 м-ээс ихгүй өндөрт байршуулах шаардлагуудыг хангаагүй нийтлэг зөрчил илэрсэн.

Зураг 5. Шаардлага хангаагүй мэдээллийн самбарын зураг



¹⁴ 8.1 Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг ажлын 14 өдөрт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ.

¹⁵ 8.2.1 барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ дүрмийн 2 дугаар хэвсрэлтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт;



Мэдээллийг шаардлагын дагуу иж бүрэн, ил тод, нээлттэй байршуулаагүйгээс төслийн хэрэгжилтэд тавих хяналт сулрах, хөрөнгийн зарцуулалтын ил тод байдал алдагдах, иргэд, олон нийт төсөл, арга хэмжээний явц, санхүүжилтийн талаарх мэдээлэлд хандах боломж хязгаарлагдах, улмаар төрийн үйл ажиллагаанд итгэх итгэл буурах үр дагавартай байна.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулсан эсэхэд захиалагч хяналт хэрэгжүүлээгүй байна.

Барилгын тухай хууль болон холбогдох стандартад заасны дагуу барилга байгууламжийн зураг төсөл, байр зүйн дэвсгэр зураг олон нийтэд нээлттэй байх, шаардлагатай мэдээллийг агуулсан самбарыг барилгын ажил дуустал байршуулуулж, хяналт хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүллээ.

А.3. Дуусаагүй барилга байгууламжид ашиглагч байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

А.3.1. Тайлант онд ашиглалтад хүлээн авсан 11 барилга байгууламжийг бүртгэж, зориулалтын дагуу ашиглаж байна.

Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 12/01 дугаар тогтоолоор улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 2025 онд бий болсон хөрөнгийн эзэмшигчийг тогтоон, хөрөнгө бүртгэх шийдвэр гарсан байна.

Тус тогтоолын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж ашиглалтад орсон 34,645.20 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 барилга байгууламж, 473.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй агуулахын барилга, 198.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 инженерийн хийцтэй худагт эзэмшигч тогтоож бүртгэх шийдвэр гарч нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

Улсын комисс хүлээлцсэн актыг үндэслэн ашиглалтад орсон дараах 11 барилга байгууламжийг бүртгэж, зориулалтын дагуу ашиглаж байна.

Хүснэгт 8. 2025 онд гүйцэтгэсэн эзэмшигч тогтоосон хөрөнгийн жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Бүртгэлд авах эзэмшигч байгууллагын нэр	Бүртгэлд тусгах хөрөнгийн дүн /сая,төг/	Гүйцэтгэгчийн нэр	Улсын комиссын акт	
					Огноо	Дугаар
1	Сургуулийн барилга, 320 суудал /Өвөрхангай, Хархорин сум/	Хархорин сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	7,368.50	Хангай-Энержи ХХК	12/28/2025	ББКД-62-0028/25
2	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Өвөрхангай, Хархорин сум/	Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг	13,510.70	Би Эмд Би констракшн ХХК	12/23/2025	ББКД-62-0022/25
3	Дотуур байрны барилга, 100 ор /Өвөрхангай, Уянга сум, 2 дугаар сургууль/	Уянга сумын ЕБ-ын 2 дугаар сургууль	2,924.20	Дүүрэнцацрах ХХК	1/16/2026	ББКД-62-0002/26
4	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Сант сум/	Сант сумын ЕБ-ын сургууль	2,770.80	"Баяндөхөмийн хурд" ХХК	1/13/2026	ББКД-62-0001/26
5	Соёлын төвийн барилга /Өвөрхангай, Баруунбаян-Улаан сум/	Баруунбаян-Улаан сумын Соёлын төв	1,707.90	Ти эл жи групп ХХК	11/24/2025	ББКД-62-0018/25
6	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Баруунбаян-Улаан сум/	Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төв	675.60	Пүүлүүбумба ХХК	11/24/2025	ББКД-62-0018/25
7	Эрүүл мэндийн төвийн барилга /Өвөрхангай, Зүүнбаян-Улаан сум/	Зүүнбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төв	688.00	Итгэлт өргөө ХХК	10/28/2025	ББКД-62-0013/25
8	Эрүүл мэндийн төвийн барилга /Өвөрхангай, Өлзийт сум/	Өлзийт сумын Эрүүл мэндийн төв	671.00	Галбын тос ХХК	12/8/2025	ББКД-62-0021/25
9	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Хужирт сум/	Хужирт сумын Эрүүл мэндийн төв	1,708.00	Воком констракшн ХХК	12/23/2025	ББКД-62-0023/25
10	Татварын хэлтсийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Арвайхээр сум/	Аймгийн Татварын хэлтэс	1,150.00	Цаст тэргүүн констракшн	7/3/2025	ББКД-62-0008/25
11	Засаг даргын Тамгын газрын барилга /Өвөрхангай, Тарагт сум/	Тарагт сумын Засаг даргын Тамгын газар	1,470.50	Хангамж өргөө ХХК	9/16/2025	ББКД-62-0012/25
ДҮН			34,645.20			

Эх сурвалж: Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2026 оны 12/01 дүгээр тогтоол

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд дуусаагүй үйлдвэрлэл дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй дараах 21 төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 52,634.8 сая төгрөгөөр /Хавсралт 1/ тусгасан байна.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дуусаагүй үйлдвэрлэл дансанд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/ төсөл арга хэмжээг 1,726.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.

Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2¹⁶, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4¹⁷, 14.4.2¹⁸, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх

¹⁶ 6.2 Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.

¹⁷ 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:

¹⁸ 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 10.42 (з)¹⁹ дахь заалтуудыг зөрчсөн тул данс бүртгэлд үнэн зөв тусгаж, зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.

Мөн дараах төсөл, арга хэмжээний гүйцэтгэл дутуу байхад комисс ашиглалтад хүлээн авснаас гүйцэтгээгүй ажлын зөрүүгээр нягтлан бодох бүртгэлд илүү бүртгэсэн зөрчил илрэв.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- Сургуулийн барилга, 320 суудал /Хархорин сум/ -ыг 7,368.5 сая төгрөгөөр гүйцэтгэхээр Хангай энержи ХХК гэрээ байгуулан гүйцэтгэсэн. Хичээлийн байрын барилгыг 2025 оны 12 сард ашиглалтад хүлээн авсан. Гадна тохижилтын ажлын тоо хэмжээнээс 736.8 сая төгрөгийн төсөвтэй ажлыг Хархорин сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль нь нягтлан бодох бүртгэлд илүү бүртгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2²⁰, 5.1.5²¹, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2²², Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4²³, 14.4.2²⁴, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.3.1.10²⁵-т заасныг зөрчсөн Орон нутгийн өмчийн газарт албан шаардлага хүргүүлэв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 4,261.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Арвайхээр сум, 13 дугаар баг/ барилгын гүйцэтгэл 95.0 хувьтай, барилгын дотор заслын ажил дутуу гүйцэтгэгдсэн, гадна тохижилт хийгдээгүй байна. Дараах шалтгаануудаас төсвийг шинэчилж төсөв 524.2 сая төгрөгөөр нэмэгдэж, нэмэлт гэрээ байгуулсан байна.

- Худалдан авах ажиллагааг магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан ажлын тоо хэмжээнээс гадна инженерийн шугам сүлжээний тоо хэмжээг хасаж зарласан.
- Зураг төслийн дагуу төсвийг боловсруулаагүй, төсөл, арга хэмжээний метр квадратын үнэлгээг алдаатай тооцсон.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Арвайхээр сум, 13 дугаар баг/ - Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллаагүй, барилга ашиглах шийдвэр гаргаагүй, ашиглалтын гэрчилгээ олгогдоогүй, дуусаагүй барилга байгууламжид Арвайхээр сумын 11 дүгээр тусгай цэцэрлэг нь үйл ажиллагаа явуулж байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4²⁶ дэх заалтын дагуу аймгийн Засаг дарга нь барилгын талаарх бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй, Барилгын

¹⁹ Үндсэн хөрөнгийг олж бэлтгэх, шилжүүлэх ажил гүйлгээг дараах байдлаар бүртгэнэ:

(з) үндсэн хөрөнгийг өөрөө барьж байгуулж байгаа тохиолдолд холбогдох өртгийг дуусаагүй барилга дансанд хуримтлуулна:

Дт Дуусаагүй барилга

²⁰ 5.1.2 "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх"

²¹ 5.1.5 "хариуцлагатай байх"

²² 6.2 Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.

²³ 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:

²⁴ 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

²⁵ 2.3.1.10.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний өмч бүртгэл, ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх;

²⁶ 35.1.4 тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах;

тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1²⁷, 48.2²⁸, 48.3²⁹, 49 дүгээр зүйлийн 49.1³⁰, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 8.2.1³¹ дэх заалтыг зөрчсөн байна.


Хууль, журам зөрчсөнтэй холбоотой оролцогч талуудын хооронд хариуцлагын маргаан үүсэх эрсдэл өндөр байна.

- Гүйцэтгэгчийн ажлын чанар, доголдлоос үүдсэн гэмтэл, зардлыг хэн хариуцах нь тодорхойгүй болох
- Захиалагч барилгыг албан ёсоор хүлээж аваагүй тул баталгаат хугацаа, үүрэг хариуцлагын эхлэх хугацаа маргаантай болох
- Ашиглагч байгууллага зөвшөөрөлгүй ашигласнаас үүдэх эрсдэл, хохирлыг өөрөө хүлээх нөхцөл үүсэх

А.3.2. Зарим салбарын хувьд төсөл, арга хэмжээний хэрэгжилт, зорилтот түвшин, хүрэх үр дүнг чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэхүйц, тодорхой байдлаар тусгах шаардлагатай байна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний үр дүн, үр ашгийг тооцох, үр дүнгийн талаарх тайланг тайлагнах талаар хууль тогтоомжид дараах байдлаар тусгасан байна.

Дүрслэл 2. Хууль тогтоомжийн схем



Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 02/11 дугаар тогтоолоор аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг баталж, хэрэгжилтийг тайлагнасан байна.

²⁷ 48.1 Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна.

²⁸ 48.2 Барилга байгууламжийг барилгын ажлын явцад шаардагдах цахилгаан, дулаан, халуун, хүйтэн усаар түр хангах бөгөөд байнгын ашиглалтад оруулаагүй барилга байгууламжийг цахилгаан, харилцаа холбоо, дулаан, халуун, хүйтэн усаар хангахыг хориглоно

²⁹ 48.3 Гэрчилгээ олгоогдоогүй, дуусаагүй барилга байгууламжид үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

³⁰ 49.1 Энэ хуулийн 48.1-д заасны дагуу ашиглалтад оруулсан барилга байгууламжид барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг үндэслэж, ажлын долоон өдрийн дотор ашиглалтын гэрчилгээ олгоно.

³¹ 8.2.1 барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ дүрмийн 2 дугаар хэвсрэлтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт;

Хүснэгт 9. Өвөрхангай аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан ХО-ын төсөл арга хэмжээний хэрэгжилтийн үзүүлэлт

Үр дүн, үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ	Хөтөлбөрийн хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилготой түвшин	Хүрсэн түвшин
1.1.2.2. Баянгол суманд баригдаж буй 240 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, Баян-Өндөр, Хархорин, Арвайхээр сумдад баригдаж буй тус бүр 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгыг үргэлжлүүлэн барьж, Уянга сумын 1 дүгээр сургуулийн урлаг заал бүхий өргөтгөлийг ашиглалтад оруулах	Боловсролын байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, шаардлага хангасан, тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлж, цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг багасгана.	Ажлын гүйцэтгэл	40	80	84
1.1.2.3. Арвайхээр сумын 150 хүүхдийн ортой 11 дүгээр (тусгай), Бүрд, Богд, Зүүнбаян-Улаан сумдад баригдаж буй тус бүр 50 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга болон өргөтгөлүүдийн гэрээнд тусгагдсан ажлуудыг дуусгах	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, нийгмийн баталгааг сайжруулж, эрүүл мэндийн ажилтны чадамжид суурилсан бүтээмжийг тасралтгүй дээшлүүлнэ.	Ажлын гүйцэтгэл	30	100	90
1.2.3.3. Зүүнбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төвийг ашиглалтад оруулж, Өлзийт, Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын нэмэлт төсвийг шийдвэрлэж ашиглалтад оруулах	Хөгжлийн бэрхшээлийн талаарх зөв ойлголт эерэг хандлагыг төлөвшүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.	Ажлын гүйцэтгэл	60	100	100
1.5.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төвийг ашиглалтад оруулах	Сумдын инженерийн шугам сүлжээний бие даасан дэд бүтцийг бий болгож, иргэдийн орон нутагт ажиллаж, амьдрах ая тухтай орчин бүрдүүлнэ.	Ажлын гүйцэтгэл	10	100	70
2.5.1.1. Уянга, Бат-Өлзий, Хужирт сумдын инженерийн шугам сүлжээний дэд бүтцийн ажлыг дуусгаж, ашиглалтад оруулж, Нарийнтээл сумдын инженерийн шугам сүлжээний ажлыг үргэлжлүүлэх	Арвайхээр хотын дулаан хангамжийн нэгдсэн эх үүсвэрийг бий болгож, агаарын бохирдлыг бууруулна.	Ажлын гүйцэтгэл	30	90	90
2.5.2.1. Арвайхээр суманд хийгдэж байгаа инженерийн шугам сүлжээний ажлыг үргэлжлүүлж, эвдэгдсэн газрыг технологийн нөхөн сэргээлт хийх	Ерөнхий төлөвлөлтийн дагуу дэд бүтцийг хөгжүүлж, орон нутагт ажиллаж, амьдрах тав тухтай орчин бий болгоно.	Ажлын гүйцэтгэл	30	70	60
2.5.3.9. Арвайхээр, Хархорин, Хужирт сумдын доторх хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулах	Шинээр баригдаж байгаа авто замын урт	Шинээр баригдаж байгаа авто замын урт	10 у/м гүүр, 50 м зам	1,6	-

Эх сурвалж: Өвөрхангай аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан боловч зарим салбарын хувьд зорилтот түвшний хүрэх үр дүнг чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэхүйц, тодорхой байдлаар тусгах шаардлагатай байна.

А.3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээнүүд хэрэгжсэнээр төлөвлөсөн бодлогын зорилтот үр дүнд хүрсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 10/02 дугаар тогтоолоор хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт, үр дүнг 87.0 хувьтай буюу “Үр дүн гарсан” гэж баталгаажуулсан байна.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөсөн бодлогын зорилтот үр дүнг тооцохдоо зөвхөн тоон үзүүлэлтээр бус, чанарын үзүүлэлтээр хүртээмж, үйлчилгээний түвшин, иргэдэд үзүүлсэн үр өгөөж, үр нөлөөг хамтатган тооцож байх нь зүйтэй байна.

А.3.4. Сүүлийн жилүүдэд нийт илэрсэн зөрчлийн тоо өссөн боловч, төлбөрийн акт, хариуцлага тооцуулах албан шаардлага буурсан үзүүлэлттэй байна.

Акт, албан шаардлага, зөвлөмжийг 3 жилээр харьцуулан үзэхэд нийт зөрчлийн тоо өссөн боловч, сүүлийн жилүүдэд төлбөрийн акт, хариуцлага тооцуулах албан шаардлага буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 10. Аудитын шийдвэрийн судалгаа /сүүлийн 3 жилээр/

Шийдвэрийн төрөл	2023	2024	2025
Албан шаардлага	6	6	8
Хариуцлага тооцуулах албан шаардлага		2	
Төлбөрийн акт	1	-	-
Зөвлөмж	3	3	4
НИЙТ ДҮН	10	11	12

Эх сурвалж: Улсын төсвийн 2022-2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн аудитын зөрчлийн нэгтгэл

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг 100.0 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Тайлангийн хавсралт:*Хавсралт 1 Барьцаа хөрөнгийн данснаас олгосон 2024 оны санхүүжилт /сая. төг/*

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгчийн нэр	Санхүүжилт	Чанарын баталгаа	Алданги
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	Юу Зэт эрдэнэ	1,726.51	-	-
2	Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн ажил гүйцэтгэх гэрээ	Пүүлүү бумба ХХК	209.33	33.79	-
3	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Хужирт сум/	Воком констракшн ХХК	334.28	170.80	10.26
4	Эрүүл мэндийн төвийн барилга /Өвөрхангай, Өлзийт сум/	Галбын тос	233.58	33.55	-
5	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Өвөрхангай, Хархорин сум/	БИ ЭНД БИ КОНСТРАКШН ХХК	3,779.87	-	-
6	Зүүнбаян-Улаан сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ	Итгэлт-Өргөө ХХК	173.78	34.43	-
7	Өвөрхангай, Баруунбаян-Улаан сумын Соёлын төвийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ	Ти Эл Жи групп	845.52	85.39	18.72
8	Арвайхээр сумын Музейн дотоод интерьерын ажил гүйцэтгэх гэрээ	БАКО констракшн	600.00	-	-
9	Соёлын төвийн барилга, 240 суудал /Өвөрхангай, Баянгол сум/	Тэрхийн ундраа	106.48	-	-
10	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Өвөрхангай, Бүрд сум, 5 дугаар баг/	Арвайншагшаа	560.97	28.05	2.21
11	Богд сумын цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ	Дөлгөөн Арвай	115.10	29.50	8.56
12	Зүүнбаян-Улаан сумын 50 ортой цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ	Сонорбүрд	174.04	29.01	6.04
НИЙТ ДҮН			8,859.46	444.52	45.79

Эх сурвалж: Барьцаа хөрөнгийн дансны 2025 оны хууль

Хавсралт 2

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эцсийн үлдэгдэл /сая.төг/
1	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга, музейн танхимын хамт /Өвөрхангай, Есөнзүйл сум/	2,151.2
2	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	1,623.2
3	Номын сан, урлаг заал бүхий сургуулийн барилгын өргөтгөл, 240 суудал /Өвөрхангай, Баянгол сум/	1,939.0
4	Спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Гучин-Ус сум/	1,374.0
5	Спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Уянга сум, 2 дугаар сургууль/	1,305.4
6	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Өвөрхангай, Баян-Өндөр сум, 5 дугаар баг/	5,495.1
7	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Өвөрхангай, Арвайхээр сум, 2 дугаар сургууль/	4,570.2
8	Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Арвайхээр сум, 13 дугаар баг/	4,261.5
9	Хүүхэд залуучуудын хөгжлийн ордны барилга /Өвөрхангай, Хархорин сум/	3,140.0
10	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	2,482.8
11	Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Өвөрхангай, Арвайхээр, Хархорин, Хужирт сум/	6,461.2
12	Соёлын төвийн барилга, 250 суудал /Өвөрхангай, Төгрөг сум, 1 дүгээр баг/	507.6
13	Сумын инженерийн шугам сүлжээний шинэчлэл /Өвөрхангай, Нарийнтээл сум/	3,423.8
14	Гэр хорооллын шугам сүлжээ /Өвөрхангай, Арвайхээр сум/	2,924.4
15	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Богд сум/	590.1
16	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Өвөрхангай, Бүрд сум, 5 дугаар баг/	393.0
17	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Өвөрхангай, Зүүнбаян-Улаан сум, 3 дугаар баг/	580.1
18	Арвайхээр сумын 50 ортой хүүхдийн эмнэлэг	4,720.7
19	Аврах гал унтраах ангийн барилга /Өвөрхангай, Хархорин сум/	2,275.2
20	Сургуулийн барилгын урлаг заал, номын сан бүхий өргөтгөлийн барилга /Өвөрхангай, Уянга сум/	1,816.3
21	Музейн дотоод интерьер /Өвөрхангай, Арвайхээр сум/	600.0
НИЙТ ДҮН		52,634.8

Тайлан баталгаажуулах тушаал:



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/14

Арвайхээр сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсэг, 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/175 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын гуравдугаар хавсралтын 3 дахь заалт, 2025 оны А/161 дүгээр тушаалаар баталсан “Аудитын шийдвэр, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, аудитаар тогтоосон албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө, оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ахлах аудитор (Б.Баяртогтох)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллан, биелэлтийг 2026 оны 10 сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхийг Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (О.Пүрэвдорж), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Мөнхбат), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Т.Ариунболд), Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Цэдэнбалжир), нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Аудитын менежер (П.Хорлоосүрэн), Ахлах аудитор (Б.Баяртогтох) нарт даалгасугай.

6225010000

D:\Auditin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

5. "Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмжийг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор статистик мэдээний бүртгэлийн маягтаар гаргаж, 5 хоногийн дотор Үндэсний аудитын газрын Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын ахлах аудитор (Б.Баяртогтох), Аудитор, эрх зүйч (Б.Нямсэмжаан)-д тус тус үүрэг болгосугай.

6. Аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах үйл ажиллагааг Ахлах аудитор (Б.Баяртогтох)-т хариуцуулсугай.

7. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг Аудитор (Р.Цэрэндолгор)-д үүрэг болгосугай.



О.БАТЖАРГАЛ

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 30 өдрийн АТХ дугаар тушаалын хавсралт



Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Мөнгөн дүн /сая.төг/
1	1. Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэлийн /Өвөрхангай - Хужирт сум/ 2024 оны ажлын гүйцэтгэлийг 32.7 хувь буюу 479.9 сая төгрөгөөр, 2025 оны гүйцэтгэлийг 38.3 хувь буюу 561.8 сая төгрөгөөр тус тус тооцон нийт 71.0 хувиар баталгаажуулан 1,041.7 төгрөгийг гүйцэтгэгч тал болох "Анда рөүд" ХХК-д олгосон. Ажлын гүйцэтгэлийг талбарт тулган баталгаажуулалт хийж, хийгдээгүй замын хучилт, тоноглол, тэмдэглэгээний ажил, явган хүний замын ажил, авто замын гэрэлтүүлгийн ажлуудыг ажлын тоо хэмжээгээр төсөвт өртгийг тооцоолоход 261.9 сая төгрөгийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон байна. 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилгын /Өвөрхангай, Арвайхээр сум/ ажлын 10.0*10.0 хэмжээтэй 2 автомашины дулаан зогсоолыг гүйцэтгээгүй байхад захиалагчийн хяналтын тайлан, хурлын тэмдэглэл, санхүүжилтийн маягтуудад барилга угсралтын гэрээт ажлын тоо хэмжээний дагуу бүрэн хийгдсэн гэж баталгаажуулан, санхүүжилтийг 100.0 хувиар тооцон гүйцэтгэгч тал болох "Юу зэт эрдэнэ" ХХК-д олгосон зөрчил илэрсэн.	303/A1571147/ ӨВА-2026/05-14- ШТА-НА	261.9
2	Эрүүл мэндийн төвийн барилга /Өвөрхангай, Хужирт сум/, Татварын хэлтсийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Арвайхээр сум/-ийн барилга угсралтын ажил гүйцэтгэсэн 2 аж ахуйн нэгж 2,858.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй, төсөвт тусгагдсан ажлыг чанаргүй гүйцэтгэсэн байна.	306/A1571147/ ӨВА-2026/05-14- ШТА-НА	6.3
3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 10 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч нь зураг төсөлд заасан ажлыг бүрэн гүйцэтгээгүй, гэрээнд тусгагдсан ажил, үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлээгүй, үүрэг даалгаврын биелэлтийг дүгнээгүй, холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангаагүй зөрчлийг арилгаагүй байхад барилга байгууламж ашиглалтад оруулах комисс барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авсан байна.	307/A1571147/ ӨВА-2026/05-14- ШТА-НА	807.6
4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилгын /Өвөрхангай, Арвайхээр сум/ ажлын хөрөнгийн бүртгэлийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дуусаагүй үйлдвэрлэл дансанд 1,726.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.	308/A1571147/ ӨВА-2026/05-14- ШТА-НА	1,726.5
5	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 7,368.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сургуулийн барилга, 320 суудал /Хархорин сум/-ын хичээлийн байрын барилгыг 2025 оны 12 сард ашиглалтад хүлээн авсан. Хархорин сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь гадна тохижилтын ажлын тоо хэмжээнээс 736.8 сая төгрөгийн төсөвтэй ажлыг гүйцэтгээгүй байхад нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.	309/A1571147/ ӨВА-2026/05-14- ШТА-НА	736.8
6	Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Арвайхээр сум, 13 дугаар баг/ - Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллаагүй, барилга ашиглах шийдвэр гаргаагүй, ашиглалтын гэрчилгээ олгогдоогүй, дуусаагүй барилга байгууламжид Арвайхээр сумын 11 дүгээр тусгай цэцэрлэг нь үйл ажиллагаа явуулж байна.	310/A1571147/ ӨВА-2026/05-14- ШТА-НА	4,261.6
Нийт			7,800.7

D:\Auditiin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

Холбогдох байгууллагын санал:



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 2376, 7032 2325,
Цахим шуудан: uvurkhangai@ov.gov.mn
Цахим хуудас: www.uvurkhangai.mn

2026. 04. 30. № 1/206
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Хархорин суманд баригдаж байгаа 320 суудалтай сургуулийн барилгын хичээлийн байрыг Барилгын тухай хуулийн 48.4-т заасны дагуу нэгдмэл бус бүрдэл хэсгийг хэсэгчлэн хүлээн авсан.

Хархорин сумын 5 дугаар цэцэрлэгийн байр нь мөөгөнцөртсөн, хана тааз нуралт үүсэж, дулаан алдагдал ихтэй, аюулгүй байдлын шаардлага хангаагүйн улмаас тус сургуулийн бага сургуулийн байранд яаралтай шилжүүлэх шаардлага үүссэн тул хичээлийн байрыг ашиглалтад оруулсан.

Дээрх барилгын гэрээний хугацаа дуусаагүй, үлдэгдэл 847,5 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй, тухай үед гадна тохижолтын ажил 67 хувьтай гүйцэтгэсэн байсан.

Мөн тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулж байсан байр нь зай талбай бага, агааржуулалтын систем байхгүй, агаар хуурайшилттай, хүчил төрөгчийн дудагдалд орох зэрэг хүүхэд, багш, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байсан тул хичээлийн шинэ байрыг зайлшгүй шаардлагаар ашиглаж эхэлсэн бөгөөд гэрээний хугацаа 2027 онд дуусахаар байгуулагдаж, үлдэгдэл санхүүжилт болох 267.1 сая төгрөг нь дараа онд олгогдохоор байна.

Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн нийгмийн байдлыг онцгой анхаарч гүйцэтгэгч компанийг өөрийн хөрөнгөөр энэ ондоо багтааж бүх ажлаа хийж дуусгах үүрэг чиглэл өгсөн.

Иймд Хархорин сумын 320 хүүхдийн хичээлийн байр, Арвайхээр сумын тусгай хэрэгцээт хүүхдүүдийн цэцэрлэгийн барилгыг зайлшгүй шаардлагаар ашиглалтад хүлээн авч хүүхдүүдийг эрсдэлгүй, аюулгүй орчинд сурч хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлж ажилласан тул албан шаардлагыг хүлээн авахаас татгалзаж байна.

О.ПҮРЭВДОРЖ

6226 14 0188

D:My Doc. A4 albanbichig /ZD/



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

Өлзийтийн 1 дүгээр гудамж, 101 тоот, 8 дугаар баг,
Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62169,
Утас/факс: (976) 7032 3720,
Цахим шуудан: uvurkhangai@gazar.gov.mn,
Цахим хуудас: www.ovorkhangai.gazar.gov.mn

2026.04.30 № 238
танай _____-ны № _____-т

**Тайлангийн төсөлд санал
хүргүүлэх тухай**

Танай газраас 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажилд аудит хийж 2026 оны 04 дүгээр сарын 28-ний өдөр ирүүлсэн ӨВА-2026/05-14-ШТА-НА дугаартай тайлангийн төсөлтэй танилцаад дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. Зохиогчийн хяналтын тоог гаргасан тайлантай танилцахад хяналт хийсэн тоо дутуу, санхүүжилтийн тайлан гаргасан тоотой харьцуулсан нь учир дутагдалтай байна. Зарим тохиолдолд гүйцэтгэгч компаниуд ажлын талбайд журналаа байлгахгүй байснаас бичилт хийгдэхгүй байх тохиолдол гардаг. Тухайлбал Арвайхээр сумын ИШС-ний 3 ажил нэг автортой байхад хяналт хийсэн тоо нь зөрүүтэй харагдаж байна. Цаашид зохиогчийн хяналтын тоог гэрээний дүнд хүргэхэд анхаарч ажиллах болно.

2. Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийн тоог тодруулж авч үзэх шаардлагатай байна. Зарим гишүүд ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй ажлыг нэмэлтээр гүйцэтгэх шаардлага тавьсан байдаг нь зөрчил гэж авч үзэх үндэслэлгүй гэж үзэж байна. Тухайлбал Баруунбаян-Улаан сумын ЭМТ-ийн өргөтгөлийн барилгын зураг төсөвт гадна тохижилт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ОО-н асуудал тусгагдаагүй байхад гадна зам талбай, ОО хийлгэх шаардлага тавигдсан, Уянгын 100 ортой дотуур байранд шалны дулаалга зураг төсөвт тусгагдаагүй байсныг шалны дотор талаас дулаалуулсан. Энэ ажил нь 2026 онд хийх ажлын төсөвт тусгагдсан байгаа нь үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тоонд бүртгэгдсэн г.м мөн, гишүүдийн өгсөн ижил үүрэг даалгаврыг давхардуулж тооцсон харагдаж байна. Хархорин сумын 320 хүүхдийн сургуулийн барилга, Хужирт Сумын ЭМТ-ийн барилга, Арвайхээр сумын тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилгуудад

622603038

онцгой нөхцөл, байдлын улмаас ашиглалтад оруулах шийдвэр гарсан болно. Эдгээрээс 2 барилгын гэрээний хугацаа дуусаагүй байгаа болно. Татварын хэлтсийн барилга, Баруунбаян-Улаан сумын Соёлын төвийн барилга, Хархорины 100 ортой эмнэлэг, Зүүнбаян-Улаан сумын ЭМТ-ийн өргөтгөл, Өлзийт сумын ЭМТ-ийн өргөтгөл, Баруунбаян-Улаан сумын ЭМТ-ийн өргөтгөлийн барилгуудын үүрэг даалгаврын биелэлт бүрэн хангагдсан болно.

Цаашид зөрчлийг үнийн дүнгээр илэрхийлэхдээ тухай бүр нь бодит ажлын тоо хэмжээг гаргаж хамтран ажиллаж баталгаажуулж байхыг хүсье.

ДАРГА

Т.АРИУНБОЛД





**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 2006, 7032 2007,
Цахим шуудан: onug.uvurkhangai@gmail.com,
Цахим хуудас: www.umch.ov.gov.mn

2026. 04. 30 № 73

танай _____-ны № _____-т

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Санал байхгүй болно.

ДАРГА *Ариун* С.ЦЭДЭНБАЛЖИР



03220779077

D:nuuts/alban bichig/jijig toot-A5/doc-

Саналд өгсөн тайлбар:

Өвөрхангай аймгийн Засаг Даргын 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 1/206 дугаартай албан бичгээр ирүүлсэн 2 саналыг хүлээж аваагүй, нотлох баримтаар тулган баталгаажуулсан болно.

д/д	Ирүүлсэн санал	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын тайлбар
1	<p>Хархорин суманд баригдаж байгаа 320 суудалтай сургуулийн барилгын хичээлийн байрыг Барилгын тухай хуулийн 48.4-т заасны дагуу нэгдмэл бус бүрдэл хэсгийн хэсэгчлэн хүлээн авсан. Хархорин сумын 5 дугаар цэцэрлэгийн байр нь мөөгөнцөртсөн, хана тааз нурулт үүсэж, дулаан алдагдал ихтэй, аюулгүй байдлын шаардлага хангаагүйн улмаас тус сургуулийн бага сургуулийн байранд яаралтай шилжүүлэх шаардлага үүссэн тул тул хичээлийн байрыг ашиглалтад оруулсан. Дээрх барилгын гэрээний хугацаа дуусаагүй, үлдэгдэл санхүүжилт 847.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй, тухайн үед гадна тохижилтын ажил 67.0 хувьтай гүйцэтгэсэн байсан.</p> <p>Иймд барилгыг зайлшгүй шаардлагаар ашиглалтад хүлээн авч хүүхдүүдийг эрсдэлгүй, аюулгүй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлж ажилласан тул албан шаардлага авахаас татгалзаж байна.</p>	<p>Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн</p> <p>5.1. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.1.1. Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйл³²д заасан барилгын үйл ажиллагааны зарчим хангагдсан эсэхийг дүгнэх;</p> <p>5.1.2. Барилгын тухай хуулийн 14.1³³, 14.2³⁴ дугаар хэсэгт заасан шаардлага хангагдсан эсэхийг дүгнэх;</p> <p>5.1.3. барилгын ажлыг зураг төсөл, норм, нормативын баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэх;</p> <p>Барилгын тухай хуулийн 14.1.1 “зураг төслийн дагуу баригдсан байх” гэж заасан тул иж бүрэн зураг төслийн дагуу хүлээж авах ба барилга ба гадна тохижилтын ажил нь тусдаа гэрээтэй, тусдаа магадлалын дүгнэлт гарсан, ажил эхлүүлэх зөвшөөрөл нь тусдаа, барилга байгууламжийг ашиглахад аюулгүй байдал хангагдсан буюу БТХ-ийн 11.1-д заасан зарчим хангасан бол зөвтгөх боломжтой тул саналыг хүлээж аваагүй.</p>

³² 11.1. Барилгын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

11.1.1. механик аюулгүй байдлыг хангах: барилга байгууламжийн материал, хийц, бүтээц, эдлэхүүн нь барилгын ажлын болон ашиглалтын үед иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх тогтвортой байх;

11.1.2. галын аюулгүй байдлыг хангах: барилга байгууламжийн ашиглалтын явцад галын аюулаас урьдчилан сэргийлэх, галын аюулаас хамгаалах, хор хөнөөлийг хязгаарлах нөхцөлийг зураг төсөлд тусгах;

11.1.3. хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах: барилга байгууламж хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр төлөвлөгдөн баригдаж, хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө болон амьтан, ургамалд аюул учруулахгүй байх;

11.1.4. хүний аюулгүй байдлыг хангах: барилга байгууламж физик, хими, биологи, цацраг, өндөр хэлбэлзлийн долгионы болон бусад хортой бодисын нөлөөллөөс хамгаалагдсан байхаар төлөвлөгдөн баригдсан байх;

11.1.5. барилга байгууламж ашиглагчдын аюулгүй байдлыг хангах: барилга байгууламж ашиглалтын явцад хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахгүй, галд тэсвэртэй, цахилгаан хангамж, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй байхаар төлөвлөгдөн баригдсан байх;

11.1.6. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах: барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөгдөн баригдсан байх;

³³ 14.1.1. зураг төслийн дагуу баригдсан байх;

³⁴ 14.2. Барилга байгууламжийн гадна тохижилтын талбай, ногоон байгууламж хот төлөвлөлтийн норм, нормативын баримт бичигт заасан хэмжээнээс багагүй байна.

2	<p>Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулж байсан байр нь зай талбай бага, агааржуулалтын систем байхгүй, агаар хуурайшилттай, хүчилтөрөгчийн дутагдалд орох зэрэг хүүхэд, багш, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байсан тул хичээлийн шинэ байрыг зайлшгүй шаардлагаар ашиглаж эхэлсэн бөгөөд гэрээний хугацаа 2027 онд дуусахаар байгуулагдаж, үлдэгдэл санхүүжилт болох 267.1 сая төгрөг нь дараа онд олгогдохоор байна.</p> <p>Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн нийгмийн байдлыг онцгой анхаарч гүйцэтгэгч компанийг өөрийн хөрөнгөөр энэ ондоо багтааж бүх ажлаа хийж дуусгах үүрэг чиглэл өгсөн.</p> <p>Иймд хүүхдүүдийг эрсдэлгүй, аюулгүй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлж ажилласан тул албан шаардлага авахаас татгалзаж байна.</p>	<p>Зайлшгүй шаардлагаар дуусаагүй барилга байгууламжид үйл ажиллагаа явуулах, зөвшөөрөл олгох эрх зүйн зохицуулалт байхгүй тул саналыг хүлээж аваагүй.</p>
---	--	--

ГХБХБГ-ын 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 238 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналыг хүлээж аваагүй, нотлох баримтаар тулган баталгаажуулсан болно.

д/д	Ирүүлсэн санал	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын тайлбар
1	<p>Зохиогчийн хяналтын тоог гаргасан тайлантай танилцахад хяналт хийсэн тоо дутуу, санхүүжилтийн тайлан гаргасан тоотой харьцуулсан нь учир дутагдалтай байна. Зарим тохиолдолд гүйцэтгэгч компаниуд ажлын талбайд журналаа байлгахгүй байснаас бичилт хийгдэхгүй байх тохиолдол гардаг. Тухайлбал Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээний 3 ажил 1 автортай байхад хяналт хийсэн тоо нь зөрүүтэй харагдаж байна. Цаашид зохиогчийн хяналтын тоог гэрээний дүнд хүргэхэд анхаарч ажиллах болно.</p>	<p>Аудитаар нотлох баримтаар тулган баталгаажуулсан тул саналыг хүлээж аваагүй.</p>
2	<p>Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийн тоог тодруулж авч үзэх шаардлагатай байна. Зарим гишүүд ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй ажлыг нэмэлтээр гүйцэтгэх шаардлага тавьсан байдаг. Тухайлбал ББУ-ын сумын ЭМТ-ийн өргөтгөлийн барилгын зураг төсөвт гадна тохижилт, ХБИ-ийн 00 ажил тусгагдаагүй байхад эдгээр ажлыг хийлгэхээр үүрэг даалгавар өгсөн, Уянгын 100 ортой дотуур байранд шалны дулаалга зураг төсөвт тусгагдаагүй байсныг шалны дотор талаас дулаалуулсан. Энэ ажил нь 2026 онд хийх ажлын төсөвт тусгагдсан, гишүүдийн өгсөн ижил үүрэг даалгаврыг давхардуулж тооцсон харагдаж байна.</p> <p>Хархорин сумын 320 хүүхдийн сургуулийн барилга, Хужирт сумын ЭМТ-ийн барилга, Арвайхээр сумын тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилгуудад онцгой нөхцөл, байдлын улмаас ашиглалтад оруулах шийдвэр гарсан болно. Эдгээрээс 2 барилгын гэрээний хугацаа дуусаагүй байгаа болно. Татварын хэлтсийн барилга, ББУ сумын соёлын төвийн барилга, Хархорин сумын 100 ортой эмнэлэг, ЗБУ сумын ЭМТ-ийн өргөтгөл, Өлзийт сумын ЭМТ-ийн өргөтгөл, ББУ сумын ЭМТ-ийн өргөтгөлийн барилгуудын үүрэг даалгаврын биелэлт бүрэн хангагдсан болно.</p>	<p>Зөрчлөөр авсан үүрэг даалгаврын биелэлтийн тоог аудитаар нотлох баримтаар тулган баталгаажуулсан тул саналыг хүлээж аваагүй ба үүрэг даалгаврын биелэлтийг комиссын акт гарсны дараа хангагдсаныг зөрчлөөс хасах боломжгүй. Цаашид зөрчлийг үнийн дүнгээр илэрхийлэхдээ бодит ажлын тоо хэмжээнд гаргаж баталгаажуулах саналыг хүлээж авлаа.</p>

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг өгч байна.

Үүнд:

- Өвөрхангай аймгийн Засаг даргаас хүргүүлсэн саналын 1.0 хувьтай тэнцэх төсөл, арга хэмжээг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан нь аймаг, орон нутгийн нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, нийгэмд үзүүлэх эдийн засгийн үр дүнтэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг бууруулсан байна.
- Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжиж эхэлсэн 11 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэлд 2025 онд хийсэн нийцлийн аудитын дүгнэлтээр төсөл, захиалагчаас ирүүлсэн төсвийн өөрчлөлтийн 10,020.2 сая төгрөгийг үндэслэлтэй гэж үзэн баталгаажуулж нэмэгдүүлсэн байна.
- Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаснаар хуульд баталсан төсөвт өртөг нэмэгдэж, улмаар төслийг гэрээний хугацаанд хэрэгжүүлэх боломж хязгаарлагдах, үр дүн саатах, гэрээний үүргийн биелэлт алдагдах, нөөцийн ашиглалтын үр ашиг буурах эрсдэл бий болсон байна.
- Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй зарим төсөл, арга хэмжээнд баримтлах хууль, журам, норм, дүрмийн шаардлагыг зөрчиж, гүйцэтгэл нь бүрэн хийгдээгүй ажлыг баталгаажуулан санхүүжилтийг илүү олгосон байна.
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн үүрэг даалгаврыг бүрэн биелүүлээгүй, гэрээнд заасан ажлыг 100.0 хувь гүйцэтгээгүй байхад комиссын дүгнэлт гарган барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авсан байна.
- Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллаагүй, барилга ашиглах шийдвэр гаргаагүй, ашиглалтын гэрчилгээ олгогдоогүй, дуусаагүй барилга байгууламжид ашиглагч байгууллага үйл ажиллагаа явуулж байна.
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дуусаагүй үйлдвэрлэл дансанд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/ төсөл арга хэмжээг 1,726.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.
- Өмнөх оны аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 3 жилээр харьцуулан үзэхэд нийт зөрчлийн тоо өссөн боловч, сүүлийн жилүүдэд төлбөрийн акт, хариуцлага тооцуулах албан шаардлага буурсан үзүүлэлттэй байна.

ЗӨВЛӨМЖ:

Өвөрхангай аймгийн Засаг дарга О.Пүрэвдорж танаа

- Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажилд зураг төсөв зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.2-т заасны дагуу зохиогчийн хяналтыг гэрээний дагуу гүйцэтгэж, тайлагнаж байгаад хяналт тавьж ажиллах;
- Барилга байгууламжид хэрэглэсэн барилгын материал, хийц, бүтээцийн үзүүлэлтэд эрүүл ахуйн шаардлагыг сорилт, шинжилгээний итгэмжлэгдсэн лабораториор сар, улирал тутамд тодорхойлуулж хяналт хэрэгжүүлж ажиллах;
- “Улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжих бүтээн байгуулалтын ажлын мэдээллийн самбарт тавих шаардлага” Монгол Улсын үндэсний стандарт MNS 7023:2023-д заасны дагуу барилга байгууламжийн зураг төсөл, байр зүйн дэвсгэр зураг олон нийтэд нээлттэй байх, шаардлагатай мэдээллийг бүрэн агуулсан самбарыг барилгын ажил дуустал байршуулж байх, хяналт хэрэгжүүлэх;

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газарт хүргүүлэх санал

Барилгын ажил гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ, хүлээлгэх хариуцлага, гэрээ цуцлах үндэслэл, эрх зүйн зохицуулалт тодорхой бус байгаа нь захиалагчийн шийдвэр гаргалт удаашрах, төсөл арга хэмжээний хэрэгжилт саатах, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг бий болгож байна.

Иймд захиалагч талаас гэрээ цуцлах нөхцөл, журам, цуцалсны дараах ажлын шилжилт, гүйцэтгэлийн болон санхүүгийн тооцоо, хариуцлага тооцох механизм, шинэ гүйцэтгэгч сонгон шалгаруулах үйл явцыг нарийвчлан зохицуулсан эрх зүйн орчныг боловсронгуй болгож, тодорхой болгох талаар холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх.

Монгол улс, Өвөрхангай аймаг
Арвайхээр сум, Нутгийн удирдлагын ордон
Утас: +976 70323253, 70323833, 70323108
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn, цахим хуудас: www.audit.mn